

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Аймгийн Онцгой комиссын хүрээнд: Улсын Онцгой комиссын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны хуралдаанаар баталсан Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын ажиллах журам, Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай хууль тогтоомжууд, Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэл, албан даалгавар болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аймгийн Онцгой комиссоос 2021 оны 02 дугаар сард дараах ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой комисс 2021 оны тайлант 2 дугаар сард 3 удаа хуралдаж Ховд аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 5 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 1 тогтоол, аймгийн Засаг даргын 2 захирамж, Онцгой комиссын даргын 1 тушаал, АОК-ын дэргэдэх шуурхай штабын 1 шийдвэр, 2 тогтоол үүрэг хүргүүлэх болон холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн 2 дугаар хагас жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлсэн.

Теле болон цахим хэлбэрээр 2021 оны 03 дугаар сарын 01-ний танхимын сургалтыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангуулж теле болон цахим хичээлийг гэрийн орчинд үзэх техникийн боломжгүй сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд сургалтын гарын авлага, хэвэлмэл болон бусад материалыг хүргэх ажлын хэсгийг Онцгой комиссын даргын тушаалаар зохион байгуулж, хяналт тавин ажиллаж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын шинжилгээ авах оношлуур, урвалж бодисын нөөцийг нэмж бүрдүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 1500 ширхэг түргэвчилсэн оношлуурыг авч нөөц бүрдүүллээ.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг вакцин татан авалт хийж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд вакцинаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/20 дугаар тушаалаар байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Улаанбаатар болон өөр аймгийн нутгаас ирж байгаа иргэдээс коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Дарви сумын хяналтын цэгт түргэвчилсэн тестээр шинжилгээг тогтмол авч байна. Улаанбаатар хот болон өөр аймгаас иргэдээ татан авах үйл ажиллагаатай холбогдуулан Дарви сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг шаардлагатай үед иргэдийг тусгаарлан ажиглах байр болгон бэлтгэж иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг сайжруулах, халдвар хамгааллын болон хорио цээрийн дэглэмийг чанд сахиулан хяналт тавин ажиллаж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах сэрэмжлүүлэг мэдээг khovdtimes, khovdnews.mn, newkhovd, www.khoa.nema.gov.mn, khovd.boet.gov.mn сайтууд болон Ховд, Олон ястан, Жаргалант, ЭКО телевиз зэрэг орон нутгийн мэдээллийн бүх сувгаар өдөр бүр 2 цагийн давтамжтайгаар иргэд, олон нийтэд хүргэн ажиллалаа.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг видео мэдээлэл, гараа угааж хэвших нь олон өвчнөөс урьдчилан сэргийлнэ “Амны хаалтаа зөв зүүцгээе зэрэг мэдээллийг байгууллагын сайт болон аймгийн Онцгой байдлын газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Бүсийн Оношилгоо эмчилгээний төв facebook хуудсанд байршууллаа.

Гэрийн ажиглалтанд байгаа нийт 801 иргэний гар утсанд “CLIX GPS” системийг ашиглан бүртгэлжүүлж хяналт тавих алба хаагчийг томилгоожуулан ажиллаж байна. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулан зохицуулахад мэдээллийн технологийн шийдэл нэвтрүүлэх, нэвтрүүлсэн мэдээллийн технологи системүүдийг бүрэн ашиглах, хүн хүчний нөөцийг дайчлах, удирдлага зохион байгууллалтаар хангаж, уялдаа холбоотой ажиллах үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Сар шинийн баяр, амралтын өдрүүд, нийслэлийн хэмжээнд тогтоосон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийслэлээс гарах, орох

чиглэлийн зорчих тээврийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/62 дугаар “Хязгаарлалт тогтоох тухай” захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирээд хязгаарлалтын дэглэмд орсон иргэдийн PCR шинжилгээг үндэслэн нутаг буцаах ажлын хэсгийг аймгийн онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 08 дугаар тушаалаар томилгоожуулан аймгийн иргэдийг хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэлд суух үед коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын урьдчилан сэргийлэх түргэвчилсэн тестээр шинжилгээ авах ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд нийтийн тээврээр нийт 205 иргэнийг PCR шинжилгээг үндэслэн татан авсан.

Хоёр: Нутгийн удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 32 өргөдөл бичгээр хүлээн авч, 25 өргөдлийг шийдвэрлэж, 7 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 6 өргөдөл бичгээр хүлээн авч, 4 өргөдлийг шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 76.3 хувьтай байна.

Засгийн газрын 1111 төвд тайлант дугаар сард гомдол 1 ирж хугацаанд нь шийдвэрлэж хаалт хийлээ.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 13 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 11, биечлэн 2 санал хүсэлт ирүүлснээс гомдол 1, санал хүсэлт 10 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 9 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 69.2 хувьтай байна.

Үүнд боловсролын асуудлаар 1, хууль эрх зүй 2, орчны эрүүл ахуйн асуудлаар 3, Эрүүл мэндийн асуудлаар 2, халаалт дулааны асуудлаар 1, Цахилгаан эрчим хүчний асуудлаар 1, бусад асуудлаар 3 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 9, 11-20 хоногтой 0, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа гомдол 4 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл, санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй болно.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр 751 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр

4099 иргэнд нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр 4850 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Гурав: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2 дугаар сард улсын төсвийн санхүүжилтээр 9532.3 сая төгрөг ирэхээс бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 317.5 сая төгрөгийн санхүүжилтээс 158.5 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 2591.9 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 1173.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 4308,5 сая төгрөг, цэцэрлэг 2100,2 сая төгрөг, хүн эмнэлэг 1176,8 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 82,2 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 92,8 сая төгрөг тус тус олгож ажиллав.

Аймгийн Засаг даргын захирамжаар сум, байгууллагуудын 2 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж баазыг Сангийн яаманд хүргүүлэн батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийн эрхийг нээлгэв. Мөн оны эцэст аймгийн төрийн сангийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн нэмэлт дансны үлдэгдэл 269,4 сая төгрөгийг байгууллагуудад Засаг даргын А/38, 51 дүгээр захирамжаар буцаан олголоо.

Нягтлан бодогчдод санхүүгийн тайланг хуулийн хугацаанд боловсруулан Э-тайланд шивүүлэхэд анхаарч, зөвлөгөө өгч ажилласнаар тайлангийн шивэлт 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-баланс системд цахим хэлбэрээр хүлээн авах, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулах зэрэг аргагүйгээр ханган ажиллаж, 2020 оны жилийн эцсийн тайланг 1827 байгууллагаас хүлээн авч, баталгаажуулж байгаа нь 86,2 хувьтай байна. Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон салбар нэгжүүдийн аудит хийсэн 11 аж ахуйн нэгж байгууллагын тайланг хүлээн авч баталгаажуулсан болно.

Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн 2020 оны жилийн эцсийн тайлан болон шийтгэлийн хуудасны тооцоог сангийн яаманд хэлтсийн даргын 5/132 дугаар

албан бичгээр хүргүүлэв. Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 10 даатгалын салбар болон даатгалын зуучлагч компанийн салбар, төлөөлөгчийн газар болох Хаан, Хас, Төрийн банкны 2020 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч нэгтгэн Санхүүгийн зохицуулах хороонд 2021 оны 5/256 дугаар албан бичгээр хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 1007 ширхэг зардлын ваучер бичиж, 7620,6 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан “SMS” МТ үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогч 300 гаруй холбогдох албан тушаалтанд мессеж хүргүүлэн чиглэл өгч ажиллав.

Төсөвт байгууллагуудын арилжааны банкин дахь дансны судалгааг Сангийн яаманд хүргүүлж 2020 оны жилийн эцэст Ойн анги 17.0 мянган төгрөг, Жаргалант сумын 15 цэцэрлэг 1.0 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байгууллагуудын дансыг хаалгав.

Аймгийн Татварын хэлтэс нь 2020 оны жилийн эцсийн хувь хүний орлогын албан татварын тайланг хүлээн авч нэгтгэх ажлын хэсгийг байгууллагын даргын тушаалаар томилж, ажлын хэсэг 15192 иргэн, ААНОАТ-ын тайланг хянан ажиллаж байна.

Тайлант сард улс, аймаг, сум орон нутгийн төсөвт 2929,6 сая өгрөг оруулахаас 2082,1 сая төгрөг орсон нь 71,0 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 664,4 сая төгрөг оруулахаас 485,1 сая төгрөг оруулсан нь 73,0 хувийн, аймгийн төсөвт 1919,9 сая төгрөг оруулахаас 1253,7 сая төгрөг оруулсан нь 65,3 хувийн, сум орон нутгийн төсөвт 345,3 сая төгрөг оруулахаас 342,5 сая төгрөг оруулсан нь 99,2 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн хяналт аудитын алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дарви, Мянгад сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалтыг хийлээ. Дарви суманд хийсэн шалгалтаар нийт сумын хэмжээнд 125 иргэн, байгууллагатай холбоотой 236,9 сая төгрөгийн зөрчил илэрч, 212,4 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөн тусалж, зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг өгч, 17,8 сая төгрөгийн төлбөрийг аймгийн орон нутгийн төсөвт оруулахаар, 350,0 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгуулахаар, 6,4 сая төгрөгийг тухайн сумын

сум хөгжүүлэх сангийн дансанд оруулахаар Улсын ахлах байцаагчийн 23 акт, Мянгад сумын шалгалтаар нийт сумын хэмжээнд 50 иргэнтэй холбоотой 18.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 8,5 сая төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар, 4,3 сая төгрөгийг данс бүртгэлд тусгуулахаар, 5,7 сая төгрөгийг сумын төсөвт оруулахаар Улсын ахлах байцаагчийн акт тус тус тогтоож ажиллав.

Статистикийн хэлтсээс аймгийн хэмжээнд ДНБ буюу нэмэгдэл өртгийн тооцоог гаргахад чухал шаардлагатай мэдээ, тайлан болох ААНБ-1, ААНБ-2 мэдээ, судалгааг ААНБ-аас авах ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2/368 дугаар албан бичгийг сумдын төрийн сангийн мэргэжилтэн, сум дундын нягтлан бодогч, аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал нягтлан бодогч нарт хүргүүлж судалгааг хүлээн авч байна.

Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан Жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэлэлцүүлэгт 2 дугаар сарын 22-ны өдөр газар, хэлтэс агентлагийн дарга нар оролцож, жендерийн үзүүлэлттэй холбоотой захиргааны статистик мэдээллийг улирал тутам гаргаж байхаар шийдвэрлэв. Энэ үеэр хэрэглэгч нарт зориулан гаргадаг аймгийн нийгэм, эдийн засгийн сар, улирал, жилийн танилцуулгын чанар, khovd.nso.mn, www.1212.mn сайтуудын талаарх ойлголт хэрэглээ, хэлтсийн үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллалаа.

Дөрөв: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Хууль эрх зүйн хэлтсээс Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Түр хамгаалах байр”-ны 9 албан тушаалтныг чадавхижуулах сертификаттай сургалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулав.

Төрийн архивын тасгаас тайлант 2 дугаар сард 17 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Эрх зүй, дотоод ажил хариуцсан ажилтан, бичиг хэргийн эрхлэгч нарт Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-аар сургалт зохион байгуулж, 1968-1977 оны 2 хөмрөгийн 2 дансны 37 хадгаламжийн нэгж буюу 3891 хуудсыг цахим хэлбэрт шилжүүллээ. 35 иргэнд архивын лавлагаа олгосноос 14 хүнд тушаал, 13 хүнд цалингийн тодорхойлолт, 8 хүнд мал тооллогын баримтаар лавлагаа олгож ажиллав.

Цагдаагийн газар: Иргэд олон нийтэд хууль эрх зүйг сурталчлан таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2021 оны 2 дугаар сард дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Яндангаас гарах дуу чимээ" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, 1572 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, 1210 зорчигчдод холбогдох хууль тогтоомжоор бэлтгэсэн гарын авлага, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг тараан өгч, яриа таниулга хийв.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Сархадгүй сар шинэ" нөлөөллийн арга хэмжээг 14 хоногийн хугацаанд зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд хэсгийн мөрдөгч, байцаагч, баг, хэсгийн цагдаа нарт хариуцсан нутаг дэвсгэрийн архины хамааралтай иргэдийн судалгааг шинэчлэн гаргаж, хяналтад авч ажиллах, сар шинийн баяр, амралтын өдрүүдэд олон нийтийн эргүүлийг хуваарь гаргаж ажиллуулах талаар үүрэг, чиглэл өгч, тус газрын алба хаагчдын facebook хаягны зургийг "Сархадгүй сар шинэ" хүрээгээр солиулан арга хэмжээнд нэгдүүлж, иргэдийг дэмжихийг уриалж тэдэнтэй хамтран ажиллалаа.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялангуяа хулгайлах, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 850 орчим иргэнд 3 хуулийн хүрээнд яриа таниулга хийж, 2 төрлийн 1600 ширхэг санамж, сэрэмжлүүлэг өглөө. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлж ажиллах талаар мэдээлэл хүргэж, 2 төрлийн 200 ширхэг зурагт хуудсыг байгууллагуудын мэдээллийн самбаруудад байршууллаа.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй баа.айх агуулга бүхий 5 зурагт хуудас мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, "АА" нийгэмлэгийн харъяа "Тунгалаг буянт" сайн дурын нийгэмлэгийн гишүүдийг оролцуулсан 2 төрлийн подкастыг бэлтгэн, khovdnews.mn, Ховд аймаг дахь Цагдаагийн газар гэсэн нэртэй пэйж хуудас /50 лайк, 6 сэтгэгдэл, 70 шэйр, 7884 хүн үзсэн/-т байрлуулан, иргэд олон нийтэд нээлттэй мэдээллээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Цагдаагийн газрын дарга, Онцгой байдлын газрын дарга нарыг оролцуулсан ард иргэдийг сар шинийн баярын өдрүүдэд архи согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх, цахимаар золгохыг уриалсан агуулга бүхий видеог /1 минут 40 секунд/ бэлтгэн орон нутгийн Ховд телевиз болон байгууллагын цахим хуудас /30 лайк, 2 сэтгэгдэл, 27 шэйр, 5357 хүн үзсэн /-аар дамжуулан иргэдэд хүргэж сар шинийн баяр, амралтын өдрүүдэд Баруун бүсийн төв Ховд аймаг дахь Онцгой байдлын газар, Зэвсэгт хүчний 123-р анги, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газрын хамтарсан 80 алба хаагч 20 автомашинтайгаар Жаргалант сумын нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг гүйцэтгэв. Мөн аймгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлж нийтийн хэв журам сахиулах чиглэлээр өдрийн эргүүлд нэмэлтээр 11:00-17:00 цагийн хооронд Цагдаагийн газрын давхардсан тоогоор 30 алба хаагч 15 чиглэлд үүрэг гүйцэтгэж, гудамж талбай, олон нийтийн газарт хяналт тавьж ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 06 дугаар тушаалаар Буянт гол, Хар ус нуурын ай сав орчимд хяналт шалгалт хийх, иргэд олноор цугларч, бөөгнөрөл үүсгэх, тээврийн хэрэгслээр чарга, дугуй чирэх зэргээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам болон өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн дэглэм зөрчих зөрчлүүдийг таслан зогсоох, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн 21 байгууллага хуваарийн дагуу эргүүл, хяналт шалгалтыг хийж, энэ хугацаанд хорио цээрийн дэглэм зөрчиж бильярд тоглоомын газар ажиллуулсан 2, хурдан морины уралдаан зохион байгуулсан 1 зөрчил илрүүлэн Цагдаагийн газрын гомдол, мэдээлэлд бүртгэн шалгаж байна.

Мөн аймгийн Засаг даргын 2021 оны А/62 дугаар захирамжаар зах, худалдааны төвүүдийн үйл ажиллагааг 5 хоног түр хязгаарлаж, архи, хатуулаг ихтэй согтууруулах ундааг Баасан гарагт худалдан борлуулахгүй байх, бусад өдөр 10:00-18:00 цагийн хооронд худалдан борлуулах, түүгээр үйлчлэх, хатуулаг багатай согтууруулах ундааг 09:00-22:00 цагийн хооронд худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тухай аймгийн Засаг даргын 2021 оны А/45 дугаар захирамжийг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд танилцуулан хэрэгжүүлж ажиллах чиглэл өгч хяналт тавьж ажиллав. Аймгийн Засаг даргын захирамж зөрчиж архи, согтууруулах ундаа худалдан борлуулсан 2 аж ахуйн нэгжийн зөрчил илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 25-ны байдлаар нийт 287 гомдол мэдээлэл хүлээн авсны 76 буюу 26,4 хувийг гэмт хэргийн шинжтэй, 211 буюу 73,5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 1, Хулгайлах гэмт хэрэг 5, мал хулгайлах гэмт хэрэг 2, залилах гэмт хэрэг 11, хөрөнгө завших гэмт хэрэг 5, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг 3, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3, Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн аюулгүй байдлын журам зөрчих гэмт хэрэг 1, Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг 1, бусад 3 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн.

Дээрх хугацаанд зөрчил гаргасан 146 хүнийг эрүүлжүүлж, зөрчил гаргасан 197 хүнийг 39530 төгрөгөөр торгож, хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 67 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 28 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж ажиллав.

Шүүхийн шинжилгээний алба: Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын дарга, эмч нартай цахимаар холбогдож шинжээч нарын дүгнэлтэнд хийсэн аудит болон цаашид анхаарах асуудлын талаар ярилцлага хийв.

Албаны 2020 оны баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивлан байнга хадгалах 35, түр хадгалах 21, 70 жил хадгалах 1, нийт 57 хадгаламжийн нэгж бүрдүүлэн байгууллагын архивын сан хөмрөгийг баяжуулж нөхөн бүрдүүлэв.

Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 5 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 42, хавтаст хэрэг 1, тусгай шинжилгээ 13, 5 криминалистикийн шинжилгээ тус тус хийж дүгнэлт гаргаж ажиллалаа. Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 30 мөрдөн байцаалтын туршилт, бусад ажиллагаанд 11 удаа тус тус оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын мөр 18 ширхэг мөр, гутлын мөр 23, тээврийн хэрэгслийн мөр 14, биологийн гаралтай ул мөр 14, эвдлэгч багажны мөр 1, бичил мөр 1, бусад ул мөр, эд мөрийн баримт 45 илрүүлж бэхжүүлэн авч гэрэл зургийн ажил 697 гарын мөрний санд гарын дардас 3, гарын мөр 3 авч баяжилт хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант сард нийт 2401 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 1754, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 347 ба шилжин ирсэн иргэд 34, аймаг доторх сумаас

суманд 164, багаас багт шилжсэн 144, гадаад паспорт олголт 42, иргэний үнэмлэх шинээр олгосон 164, сунгалт 102, дахин олгосон 65, иргэний бүртгэлийн лавлагаа 674 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 360 бүртгэлийг хийж, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 535, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 112 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав.

Тав: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: 2021-2022 оны хичээлийн жилд үндэсний хэмжээний эхний жил, 5, 10 жилийн үндсэн сургалтад хамрагдах сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын нэрс болон мэдээллийг сургууль, цэцэрлэгийн мэдээллийн системээс татан авч нэгтгэн сургалтад хамрагдах багш нарын мэдээллийг google drive ашиглан сургуулиуд болон хариуцсан мэргэжилтэнд хүргүүлснээр эхний жилийн сургалтад 162, 5 жилийн сургалтад 54, 10 жилийн сургалтад 54 багш ажилтны нэрсийг хянаж БМДИ-д илгээлээ.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас “Боловсролд тэгш хамруулан сургах” сургалтын туршлага солилцох онлайн сургалтыг 2 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, сургалтад 24 сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежер, багш нарын төлөөлөл 65 хүн оролцлоо. Сургалтаар “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн үр дүнг танилцуулж, хуримтлуулсан туршлага мэдлэгээ хуваалцаж цаашид хамтран ажиллах талаар санал солилцов.

Ховд их сургууль, Байгалийн шинжлэл технологийн сургууль, Боловсрол судлал арга зүйн тэнхимээс зохион байгуулж буй хүүхэд гэр бүлийн чиглэлээр нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх, олон нийтийн нийгэм сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий нээлттэй сургалтад СНА, сэтгэл зүйч, дотуур байрын багш нар хамрагдаж байна.

Төрийн өмчийн 34 цэцэрлэгийн туслах багш нарын судалгааг шинэчлэн гаргаж, тэднээс санал хүсэлт авсны дагуу Бага насны хүүхдийн хөгжлийн төвтэй хамтран 210 туслах багшид гэрчилгээ олгох, чадваржуулах сургалтыг 2 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулж чадавхжууллаа.

Төрийн болон хувийн 44 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нарт зориулсан “Сургалтын хөтөлбөр, орчин” сэдэвт сургалтад нийслэлийн СӨБ хариуцсан мэргэжилтэн 3.Болормаа оролцон онлайнаар холбогдож оролцогчдод цар тахлын үед

орхигдсон агуулгыг нөхөх, сургалтын орчин бүрдүүлэх, эцэг эхчүүдтэйгээ хамтран хүүхэд хамгааллын бодлогод анхаарч ажиллах чиглэл өгч нийт 270 багш хамрагдлаа.

Зөвлөн туслах арга зүйн ажлын хүрээнд “Суралцагч бүрийн суралцахуйг дэмжихэд аймаг нийслэлийн боловсролын газрын үүрэг оролцоо, мэргэжил арга зүйн дэмжлэг” хэлэлцүүлэг зохион байгууллаа. Мөн “Математик, мэдээллийн технологийн багш нарын цахим групп”-ээр дамжуулан МУИС-ийн 1, МУБИС-ийн 2, Боловсролын хүрээлэнгийн 1 судлаач эрдэмтийн баг онлайн сургалт хийж 130 багш хамрагдлаа. Тайлант сард 75 удаагийн цахим хичээл хамтран боловсруулж, математик, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн 16 удаагийн цахим хичээл боловсруулж мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

Элсэлтийн ерөнхий шалгалтын 2021 оны бүртгэл 2 дугаар сарын 25-ны өдөр эхэлсэнтэй холбогдуулан бүртгэл хийлгэхээр ирсэн 3 иргэнд зөвлөгөө өгч, цахимаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэлийг эрчимжүүлэх судалгаанд суурилсан давтлага хичээлийг зохион байгуулахаар урьдчилсан сорил авахад Химийн хичээлийн сорилд 25 сургуулийн 238 сурагч хамрагдаж аймгийн дундаж үнэлгээ 42% буюу өмнөх сорилоос 1% ахисан, 2 дугаар сорилоос дээд гүйцэтгэл 91% буюу 9% буурсан доод гүйцэтгэл 11% буюу 1% өссөн, Биологийн хичээлийн сорил-3"-д нийт 246 сурагч оролцсон, дундаж гүйцэтгэл 55% дээд гүйцэтгэл 95,3% өмнөх сорилоос 1,5% ахисан хамгийн бага гүйцэтгэл 7% буюу 2 дахь сорилоос 2,6% буурсан дундаж оноо 14% иар өссөн үзүүлэлттэй,

Монгол хэлний элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэлийг эрчимжүүлэх судалгаанд суурилсан давтлага хичээлийн сорилыг элсэлтийн ерөнхий шалгалтын журмын дагуу 80 минутын сорил шалгалтад аймгийн төвийн 72, хөдөөгийн 116, нийт 210 сурагч хамрагдаж, дундаж 50.3 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх сорил 4-өөс 7.4 хувиар буурсан үзүүлэлттэй,

ЭЕШ-ын урьдчилсан орос хэлний хичээлийн ээлжит сорилд сонгосон 17 сурагч оролцож гүйцэтгэлийн хувь 54,7 байгаа нь өмнөх сорилоос 0,7% ахисан, Англи хэлний ээлжит сорилд 286 сурагч оролцож 51% -ийн үзүүлэлттэй,

Нийгмийн ухааны сорилд 459 сурагч оролцож дундаж гүйцэтгэл 53,3% буюу өмнөх сорилоос 7,7% -иар ахисан тус тус үзүүлэлттэй байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын судалгаа шинжилгээний ажлын арга зүйг дэмжих, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж сургалтын үйл

ажиллагаатай уялдуулах зорилгоор жил бүр үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг 54 дэх илтгэлийн уралдаан “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт танхимын ба цахим хичээлийн асуудал, шийдэл” сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулагдаж дээрх уралдаанд ерөнхий боловсролын сургуулийн 23, сургуулийн өмнөх боловсролын 26, нийт 49 илтгэлээс, 2 дугаар шатанд 10 илтгэл хэлэлцэгдэж I байранд Лаборатори 1 дүгээр сургуулийн багш Г.Эрдэнэбат, II байранд Цаст-Алтай цогцолбор сургуулийн багш Х.Нямсүрэн, III байранд Дарви сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш Б.Нандинцэцэг нарын илтгэл тус тус шалгарч, үндэсний хэмжээнд 3 дугаар шатанд оролцохоор болов.

Цэцэрлэгийн эрхлэгчдийн онлайн уулзалтыг 7 хоног бүрийн Мягмар гаригт буюу 2021 оны 02 дугаар сарын 2, 16, 23, 25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Цэцэрлэгийн эрхлэгчдэд цаг үеийн мэдээллээс гадна сургалтын хөтөлбөрт анализ хийж, орхигдсон агуулгыг нөхөж буй ажлын арга туршлагаа харилцан солилцож ажиллаж байна. Түүнчлэн 7 хоног бүр сургуулийн өмнөх боловсролын хүүхдийн ирц, хийсэн ажлын товч мэдээллийг нэгтгэж, БШУЯ-д явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4-д тусгагдсан “Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэг, дотуур байрны гаднах нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солиход нэн шаардлагатай судалгааг гаргаж БШУЯ-д, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.1.2, 8.1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн дэлгэрэнгүй мэдээлэл судалгааг 5 маягт 40 үзүүлэлтээр гаргаж Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлж, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цалингийн сан, хүний нөөц, орон тооны судалгаа мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчин, номын сангийн үйл ажиллагаа болон ус, ариун цэврийн байгууламжийн статистик мэдээг тус тус гаргаж боловсролын удирдлагын мэдээллийн систем www.esis.edu.mn-д сайтад байршууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Иргэдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг дээшлүүлэх ялангуяа ковид-19 халдвараас сэргийлэх чиглэлээр Ховд телевиз болон гэрээт сайтуудаар ахуйн осол гэмтлээс сэргийлье, коронавируст

халдвар (covid-19)-аас гэртээ орохдоо юу анхаарах вэ? гадаргууг хэрхэн халдваргүйжүүлж цэвэрлэх талаар 20 төрлийн сэрэмжлүүлэг, 6 удаагийн мэдээ, танилцуулга хийж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх инфографик, шторк, архидан согтуурахаас сэргийлэх 1 удаагийн нэвтрүүлэг явуулж нийт 32187 иргэн хандаж, 410 иргэн хуваалцсан байна.

“Маска зүүж, гараа угаая” аяны хүрээнд Жаргалант сумын өрх толгойлсон, нэн ядуу эмзэг бүлгийн 7-13 насны хүүхдүүдтэй 17 айлуудад ариутгал халдваргүйтгэлийн хэрэглээний зүйлс өгч, бохир гараар дамжих халдвар, түүнээс урьдчилан сэргийлэх, амны хаалтыг зөв зүүж, тайлах, шаардлагагүй тохиолдолд гадагшаа гарахгүй зорчихгүй байх, гэртээ ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ байнга хийх талаар мэдээлэл өгч, сургалт хийлээ.

“Архидан согтуурахаас сэргийлэх” аяны хүрээнд сэтгэц наркологийн эмч Ховд ТВ-ээр архи, тамхины хор хөнөөлийг сурталчлан, 243 иргэнд мэдээлэл хүргэж, 4 төрлийн инфографик, шторкийг гэрээт ТВ болон сайтуудаар дамжуулан хүргэж ажиллалаа.

Эмч эмнэлгийн ажилчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, цаг үеийн ажлаар мэдээлэл хүргэх ажлыг тайлант сард 12 удаа хүргүүлснээс 7 удаагийн сургалтаар 565 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж мэдлэг, мэдээллээ дээшлүүлжээ.

Тайлант 2021 оны 2 дугаар сард ковид-19 халдварын голомтот бүс нутгаас ирсэн 1258 иргэнийг журмын дагуу үзлэг оношилгоонд хамруулан, мэдээллээр хангаж, Бэлгийн замын дамжих үзлэг шинжилгээнд ХДХВ-ийн шинжилгээнд 1635, тэмбүүгийн шинжилгээнд 1635 хүн хамрагдсанаас 17 тэмбүүгийн халдвартай хүн шинээр оношлогдсон. Үүнээс 5 жирэмсэн эх шинээр тэмбүү оношлогдож хавьтлын хамт эмчилгээнд хамруулж Булган, Дуут, Мөст, Чандмань, Үенч, Цэцэг, Мөнххайрхан, Дарви, Зэрэг, Манхан сумдын эрүүл мэндийн төвүүд нойтон түрхэцийн аргаар мазокийн шинжилгээ хийж трихомониаз 4, заг хүйтэн 2-ийг оношилж эмчилгээнд хамруулж байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдах иргэдийн судалгааг анхан шатны 22 эрүүл мэндийн байгууллагаас авч нэгтгэн 01 сарын мэдээгээр артерийн даралт ихсэлтийн илрүүлэг үзлэгт 1425, чихрийн шижингийн илрүүлэг үзлэгт 1148, сүрьеэ өвчний илрүүлэг үзлэгт 304, элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 959, бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 22, ходоодны хорт хавдрын илрүүлэг үзлэгт 159, хөхний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 1227, умайн хүзүүний хорт хавдрын

илрүүлэгт 116, түрүү булчирхайн хорт хавдрын илрүүлэг үзлэгт 20 иргэнийг тус тус хамруулаад байна.

Тус сард Коронавируст халдвар /ковид-19/-ын эсрэг вакцинаар иргэдийг дархлаажуулах ажлыг орон нутагт зохион байгуулах ажлын хэсэг, ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/99 дүгээр захирамжаар батлуулан, ажлын хэсгийн хурлыг нэг удаа хийж бэлтгэл ажлын талаар хэлэлцсэнээс гадна “Коронавируст халдвар (Ковид-19) эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв хамтран 2021 оны 02 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулж, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн дарга, бусад мэргэжилтэн, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрхийн эрүүл мэндийн төв, нийт 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллүүд оролцож, мэдээлэл авлаа.

Мөн аймгийн хэмжээнд Ковид-19 вакцинжуулалтын үйл ажиллагаанд ажиллах вакцинаторын судалгаа, цахим эрх нэмэлтээр авах сувилагч нарын судалгааг тусгай маягтын дагуу гарган Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүллээ.

Иргэдийн эрүүл аж төрөх ёсыг сайжруулахаар Нийгмийн эрүүл мэндийн төвөөс “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн эрүүл хооллолт” зөвлөмж 168 ширхэг, Эрүүл мэндийнхээ төлөө жорлонгоо сайжруулцгаая 720 гарын авлагыг авч сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хуваарь гарган тарааж эхлэх гэж байна.

Тайлант 2021 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгсэл болон жирэмсэн, хөхүүл эхэд олгогдох олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн захиалгыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн, Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж 2 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Эмийн хангамжийг тогтворжуулах зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сумын нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн 2021 оны эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторын урвалж оношлуур худалдан авах тендерийн 5, 9, 13, 14, 19, 22, 31, 35 дугаар багцуудын тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу tender.gov.mn цахим системээр дамжуулан 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зарлан 02 дугаар сарын 04-ний өдөр тендерийн

нээлт хийж, 8 компани үнийн санал ирүүлэн оролцсон бөгөөд үнэлгээний хорооны дүгнэлтээр 6 компани шалгарч гэрээ байгуулан, нийлүүлэлт хийгдэж эхэллээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар байгуулагдсантай холбогдуулан эмийн эргэлтийн сангийн одоогийн нөхцөл байдлын талаарх асуумж судалгааг 16 сумын эмийн эргэлтийн сангаас авч нэгтгэн хүргүүллээ.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2021 оны 01 дүгээр улирлын хурлаар 23 эрүүл мэндийн байгууллагын асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргалаа. 2021 онд магадлан итгэмжлэлд орох Буянт, “Ивээл” уламжлалт анагаах ухааны эмнэлэг, Мөст, Ховд, Чандмань, Булган сумдын эрүүл мэндийн төвүүдийг баримт бичиг бүрдүүлж өгөх талаар албан бичиг хүргүүллээ.

Гамшгийн бэлэн байдлын чиглэлээр түргэвчилсэн оношлуур болон PCR шинжилгээний мэдээг өдөр бүр холбогдох 4 цэгээс нэгтгэн мэдээлж, 2 дугаар сарын 25-ны байдлаар он гараад түргэвчилсэн оношлуураар 4320 хүнд, PCR шинжилгээг 1210 хүнд үүнээс Баян-өлгий аймгийн 45, Увс аймгийн 165, Ховд аймгийн 1000 сорьцонд PCR шинжилгээ хийжээ.

Өвөлжилтийн мэдээг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн ажиллаж, 2021 оны 02 сарын 10-ны мэдээгээр 867 иргэн отроор яваагаас жирэмсэн 9, 0-5 насны хүүхэд 179, өндөр настан 33, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 46, архаг суурь өвчтэй иргэн 15 байна. Аймгийн эрүүл мэндийн салбарын эмнэлгийн байгууллагуудад шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг сум, өрхийн эрүүл мэндийн төв, Булган нэгдсэн эмнэлэг, БОЭТ-өөс авч нэгтгэн, 8 чиглэлээр 554 ширхэг нэр төрлийн тоног төхөөрөмж шаардлагатай байгааг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад албан бичгээр хүргүүллээ.

Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний тусгай зориулалтын 2-р сарын сумдын 1016300.4 мянган төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 160518.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, салбарын хэмжээнд 42743,8 мянган төгрөгийн авлагатай, 27450,0 мянган төгрөгийн өртэй байна.

2021 оны 2-р сарын мэдээ дараа сард гарах тул 1 дүгээр сарын мэдээгээр нийт 33672 иргэдэд эмчийн үзлэг хийсний 7033 буюу 20.8 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж төрөлт 175 бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 3 тохиолдлоор нэмэгджээ.

Нялхсын эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 5.6 промилль буюу өмнөх оны мөн үеэс 6 промилээр буурсан, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 5.6 промилль буюу өмнөх оны мөн үеэс 6 промилээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн чиглэлээр: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS програмд 2021 оны 2 сарын 23-ны өдрийн байдлаар ажил хайгч иргэд 1788, үүнээс 884 эмэгтэйчүүд байна. Тайлант сард нийт 49 иргэнийг шинээр бүртгэж, идэвхгүй жагсаалтанд байсан 220 иргэний мэдээллийг шинэчиллээ. Шинээр бий болсон 11 ажлын байрыг бүртгэж бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS програмд шивж баталгаажууллаа.

Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 207 ажлын байрны захиалга авч 57 иргэнийг ажлын байранд зуучилсан. Үүнээс байнгын ажлын байранд 44, улирлын ажлын байранд 3, түр ажлын байранд 10 иргэн зуучлагдсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөөг 33 иргэнд үзүүллээ.

Орон нутгийн төсвөөс Нийгмийн халамжийн санд 25.000.000 төгрөг, Улсын төсвөөс Халамжийн тэтгэвэрт 940.000.000 төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжид 370.000.000 төгрөг, Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид 190.000.000 төгрөг, Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжид 171.392.000, ХБИргэдэд үзүүлэх хөнгөлөлт тусламжид 68.000.000 төгрөг, Хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид 218.760.000 төгрөг, Банкны шимтгэлийн санхүүжилт 1.800.000, нийт 1.984.952.000 төгрөгийн санхүүжилт авч халамжийн сангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд аймгийн хэмжээнд 2021 оны 2 дугаар сарын байдлаар 35229 хүүхдийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулсан ба шинэ төрсөн 298 хүүхэд бүртгүүлсэн байна. "Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн зарим үзүүлэлтийг баталгаажуулах ажлын заавар"-ын дагуу Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан боловч мэдээлэл нь зөрүүтэй гарсан өрхүүдээс 1 өрхийн мэдээллийг баталгаажууллаа.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 1548 өрхийн 4727 том хүн, 4037 хүүхдэд 107.928.000 төгрөгийн төсөв зарцуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2021.02.03-ны өдөр хуралдаж 21 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 17 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамрууллаа.

2020 онд Ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх гэрээт байгууллагад амарч сувилуулсан хүний тоо, олгосон мөнгөн дүнгийн мэдээллийг нэгтгэн гаргаж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлжээ. 2020 онд нийт 16 ахмадын сувилалд 110 ахмад настан, 6 ахмадын амралтанд 697 ахмад настан, нийт 22 ахмадын амралт сувилалд 807 ахмад настан амарч сувилуулав.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 3988 даатгуулагчийн 260116.7 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 2152 даатгуулагчийн 142361.3 мянган төгрөгийн орлого, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 803 ажил олгогчийн 12154 даатгуулагчийг хамруулж нийгмийн даатгалын санд 2937213.5 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлжээ. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 9616 иргэнд 7385,1 сая, тахир дутуугийн тэтгэвэр авагч 1584 иргэнд 991,7 мянган төгрөг, тэжээгчээ алдасны тэтгэвэр авагч 654 иргэнд 425,8 мянган төгрөг, цэргийн алба хаасны тэтгэвэр авдаг 306 иргэнд 425,3 мянган төгрөг, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тахир дутуугийн тэтгэвэр авагч 38 иргэнд 32,5 мянган төгрөгийн тэтгэвэр тус тус олгоод байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас: Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 226 даатгуулагчид 358136.5 мянган төгрөг, ХЧТА-н тэтгэмжид 122 даатгуулагчид 189411.9 мянган төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид шинээр 71 хүн давхардсан тоогоор 205 даатгуулагчийн 137290.4 мянган төгрөг, 43 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 43 сая төгрөг тус тус зарцууллаа. ЭХМК-с нь талынт 2 дугаар сард 2 удаа хуралдаж нийт 195 иргэний ХЧА-н асуудал хэлэлцэн шийдвэрлэж 30 иргэнд шинээр ХЧА-г тогтоож, 150 иргэний ХЧА-ыг сунгаж, 10 иргэний ХЧА-г цуцалж, шилжсэн 1 мэдээллийн баазад 2941 иргэн бүртгэлтэй байна.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр төлөвлөсөн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих “Монгол гэр бүл” хөтөлбөрийг боловсруулж байна.

Уг хөтөлбөрт төрийн болон төрийн байгууллагуудын оролцоог хангаж, санал авах зорилгоор 3 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2021 оныг архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх жил болгон зарласантай холбогдуулан архины хамааралтай иргэдэд чиглэсэн ажлын төлөвлөлт хийх хамтран ажиллах уулзалтыг Цагдаагийн газар, тунгалаг Буянт АА бүлэг ТББ-тай хамтран уулзалт зохион байгуулж 15 иргэнийг сонгон зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаж байна.

Ковид 19 цар тахлын үед тэргүүн шугамд ажиллаж байгаа Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төв, Мэргэжлийн хяналтын газар, Зэвсэгт хүчний 0123-р анги, Авто тээврийн газар зэрэг байгууллагуудаас тусламж дэмжлэг шаардлагатай 70 өрхийн судалгаа ирүүлснээс 10 өрхөд хүнсний болон ахуйн хэрэглээний багцын дэмжлэг үзүүлээ.

Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд 8 хүүхэд, 10 насанд хүрэгч нийт 18 үйлчлүүлэгч, давтан уулзалтанд 9 үйлчлүүлэгч хамрагдсан. Хүүхэд, насанд хүрэгчдээс мэдээлэл цуглуулах, асуудлын шалтгааныг илрүүлэх, хувийн онцлог, асуудлын түвшингээс нь хамааран тохиромжтой гэж үзсэн дасгал, техникүүдийг ашиглан үйлчилгээ үзүүлж байна. Давтан үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчидтэй ярилцахад харилцаа, өөрийн үнэлэмж, өөртөө итгэх итгэлд эерэг ахиц дэвшил гарч байгаа гэдгээ илэрхийлсэн. Сөрөг зан үйлийг нь өөрчилж, эерэг зан үйлийг бий болгох, эерэг дадлыг бий болгоход өөрийн хяналтын картыг хөтлүүлж, эерэг бататгал хийж байгаа нь эерэг ахиц, дэвшил гарахад ихээхэн нөлөөллийг үзүүлж байна.

Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын чиглэлээр: 2021 оны 01 сарын 28-аас 02 сарын 23-ыг хүртэлх хугацаанд 16 гомдол мэдээлэл хүлээн авч ажилласан. Гомдол мэдээлэл ирүүлсэн байдал Хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсаар 8, амаар 2, бичгээр 5, утсаар 1 байна. Хүүхдийн эрх зөрчигдсөн 11, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 4, дэмжлэг хүссэн 1 гэсэн төрөлтэй байх бөгөөд 36 иргэнд зөвлөгөө өгч, дэмжих үйлчилгээнд 18 гэр бүлийг хамруулж ажиллалаа. Эрх нь зөрчигдсөн хамгаалал шаардлагатай 45 хүүхэд, насны ангилал нь 0.1 сартайгаас 19 хүртэлх насны эрэгтэй 24, эмэгтэй 21 хүүхэд, өсвөр үеийнхэн байна.

Хамтарсан багт шилжүүлсэн 11 гомдол мэдээлэл, нөхцөл байдлын үнэлгээг 10 гэр бүлд хийж, хүүхдийн эрсдлийн үнэлгээг 8 хүүхдэд, гэр бүлийн хүчирхийллийн

нөхцөл байдлын үнэлгээг 4 гэр бүлд, аюулгүй байдлыг хангах үйлчилгээг 6 гэр бүлд, гэр бүлд нь эргэн нэтгэсэн 3, холбон зуучлах үйлчилгээнд 9 гэр бүл, гэр бүлийн дэмжих үйлчилгээнд 3 гэр бүлийг хамруулж ажиллалаа.

Хамтарсан багийн хурлыг 4 удаа зохион байгуулж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 4 гэр бүлийн 7 насанд хүрэгч 6 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж ах дүү хамаатан садан, хамтарсан багийн хяналтанд шилжүүлэн хяналт тавин ажиллаж байна.

Бага насны 2 хүүхдээ үл хайхрах хүчирхийлэлд өртүүлсэн 21 настай эмэгтэгийн гаргасан зөрчилд шалгах ажиллагаа явуулж Зөрчлийн тухай Монгол улсын хуулийн 6.20 дугаар зүйлийн 7-д зааснаар 300.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж шийдвэрлэв.

Гэр бүлийн хүчирхийлэлд удаа дараа өртсөн 1 өрхийн 5 хүүхдийн кейсийг холбогдох сумын хамтарсан багт тохиолдол шилжүүлэх маягтаар хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.

Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хурдан морины үсэргээ, сунгаа зохион байгуулж онцгой нөхцөл байдлын дэглэм зөрчиж хүмүүсийн бөөгнөрөл бий болгосон нөхцөл байдал үүсгэлээ гэх иргэний мэдээллийн дагуу ажиллахад хэсэг уяачид 2 насны 27 орчим морьд уралдуулж 20 гаруй автомашин цугларч Монгол улсын Засгийн газрын 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын захирамж зөрчсөн асуудлыг аймгийн Цагдаагийн газарт мэдэгдэж шалгуулж арга хэмжээ тооцуулан ажиллав.

Зургаа: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Аймгийн Онцгой комиссын дэргэдэх шуурхай штабын 2021 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолын хүрээнд Улаанбаатар хотоос иргэдээ татан авахтай холбоотойгоор иргэдийн гэрийн ажиглалтад хяналт тавьж, халуун хэмжих, асуумж авах, санамж тараах, хөдөө орон нутагт зорчсон иргэдэд утсаар мэдэгдэх, зах худалдааны төвүүдэд үйл ажиллагаа эрхлэгчдийн халдваргүйжүүлэлтийн дэглэм хэрхэн сахиж байгаад хяналт тавих зэрэг ажиллагааг Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд сумын Онцгой комиссын гишүүд шуурхай зохион байгуулж, 14 хоногийн хугацаагаар гэрийн тусгаарлалтад байгаа өрхийн гадна байрлан 24 цагаар хяналт тавин ажиллав. Сумын 12 багийн эмзэг бүлгийн 200 өрхөд Хүнсний тусламж, 10 багийн 40 өрхөд

“Номин Шилтгээн” ХХК-аас 20 тн-ын нүүрсний тусламж өгөх ажлыг хамтран зохион байгууллаа. Сумын 9 алдартан шалгаруулах журмын дагуу шилдэг багш, эмч, сурагчийг шалгаруулж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг даргын нэрэмжит “Гэрэлт ирээдүй” тэтгэлэгт 2021 онд шинээр хамрагдах бүтэн өнчин хүүхдүүдийн судалгаа мөн архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж ГБХЗХГ-т хүргүүлэв.

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага нь цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “КОВИД-19” халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хүмүүнлэгийн хариу арга хэмжээ авах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж олон нийтэд чиглэсэн мэдээ мэдээлэл түгээх, хүмүүнлэгийн буцалтгүй тусламж үзүүлэх ажлын хүрээнд сумын 12 багийн өрхийг сонгож, хамтран хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон тусламж хүргэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Сумын “Аварга малчин”, “Тэргүүний тариаланч”, “Шилдэг үйлдвэрлэгч”-ийн баримт бичгийг багийн айл өрхүүдээс хүлээн авч нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээ. “Аварга малчин”-аар Бугат багийн иргэн О.Очиртогтох, “Тэргүүний тариаланч”-аар Буянт багийн иргэн З.Дамиранжав, “Шилдэг өрхийн үйлдвэрлэгч”-ээр Алагтолгой багийн иргэн Г.Хонгороо нар шалгарлаа.

Сумын онцгой комиссын 2021 оны 03 дугаар шийдвэрийн дагуу сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 9 зах, 4 бөөний төвд “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж ажилласан ба Мал эмнэлэгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/4, аймгийн Мал эмнэлэгийн газрын даргын 2021 оны А/6 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж мах махан бүтээгдэхүүнд мал эмнэлэгийн магадлан шинжилгээний QR код бүхий гэрчилгээ олгох туршилтын ажлыг явуулж нийт 588 кг махыг шинжилгээнд хамруулж 57 магадлан шинжилгээний гэрчилгээ олгож, 115 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил хийв.

Сумын Засаг даргын 2021 оны А/18 дугаар захирамжийн дагуу Ховд хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад нийтийн эзэмшлийн талбайд байгаа хайс хашлагуудыг хариуцуулан өгч мөсжүүлэх үүрэг өгч ажилласнаар сумын хэмжээнд 75 аж ахуйн нэгж байгууллагууд хамт олны идэвх санаачлагаар нийт 15689.97м² хэмжээтэй 260 ширхэг тагтнаас 12321.51м² хэмжээтэй 199 тагтанд мөсжүүлэх ажлыг хийж гүйцэтгээд байна.

Буянт голын хачир дэлгэн шар усны үер гүйж, Жаргалант сумын Рашаант багийн нутагт гол дагуу оршин суугч зарим айл өрхүүд усанд автах болзошгүй нөхцөл байдал үүссэний улмаас багийн иргэд аймгийн Онцгой байдлын газартай хамтран далан хаалт хийж усанд автах эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулав.

Аймгийн Эрчим хүч зрхицуулах зөвлөлөөс зохион байгуулсан “Дулаан орчин-хэрэглэгчийн ая тух 2021” аяны хүрээнд сумын Засаг даргын А/29 дугаар захирамжаар ажлыг хэсэг томилогдон “Ховд дулааны станц” ТӨХК, “Бадамлах дөл” ХХК, “Шим-ус” ОНӨААТҮГ, “Цахилгаан түгээх сүлжээ” ХХК зэрэг байгууллагуудад хяналт тавин ажиллаж тайланг 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/136 тоот албан бичгээр аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд хүргүүлэн ажиллалаа.

Эрдэнэбүрэн сум: Сумын ИТХ, ЗДТГ, баг, байгууллагуудтай хамтран цаг үеийн мэдээллийг хүргэх зорилгоор "Малчдаа сонсьё" аян өрнүүлэн хөдөөгийн малчин өрх бүрээр орж, санал хүсэлтийг нь сонсож, 2020 оны ажлын тайлан, 2021 оны зорилтоо танилцуулж, цэцэрлэг, сургуулийн сурагчдын гэрийн даалгаврыг үзэж, зөвлөн тусалж, соёлын биет болон биет бус өвийн судалгаа авч, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Арвандолдугаар жарны "Цөөвөр" хэмээх Цагаагчин үхэр жилийн босгон дээр "Сумын аврага малчин гэр бүл"-ийг шалгаруулж алдаршуулан сумын Уяачдын холбоотой хамтран сумын шилдэг уяач, шилдэг хүлэгч хүүхэд, алтан хараацай, алдарт уяачдаа тодруулж, цол тэмдэгийг гардуулав.

Төмөр хулгана жилд сум орон нутгийн хөгжил цэцэглэлтэнд бодит хувь нэмэр оруулж, нийгмийн хариуцлага иргэний үүргээ биелүүлэн, амьдрах орчноо хувийн санаачлагаар сайжруулан шинээр байшин барьсан хашаа шинээр татаж тохижуулсан 22 өрх гэр бүлд сумын Засаг даргын дурсамж хадгалуулав.

Дөргөн сум: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, сар шинийн баяр болж байгаатай холбогдуулан сумын Засаг даргын А16 тоот захирамжаар сумаас орох, гарах нийтийн болон тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2021 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 16:00 цагаас 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийг дуусталх хугацаанд хязгаарлалт тогтоож, сумын хэмжээнд Цагаан хаалга, Далантай баруун, Далантай зүүн, Шандас, Мөсөн зам 5 цэг дээр хөдөлгөөнт эргүүл ажиллуулж, хяналт тавин ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдан төрийн албан хаагч, ард иргэдээс санал авч нэгтгэн, боловсруулж, аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хянуулахаар төслийг хүргүүлээд байна.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем egr.e-mongolia.mn сайт нэвтэрч, албан бичиг боловсруулалт, ирсэн явсан бичгийн бүртгэл хяналтыг цахимаар явуулдаг болсноор тайлант сард 39 албан бичгийг цахимаар хүлээн авч, холбогдох газарт 7 албан бичиг хүргүүлэн ажиллаж, төрийн үйлчилгээний нэгдсэн системээр иргэдэд лавлагаа мэдээллийг шуурхай өгч байна.

Сумын хэмжээнд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн татвар санхүүгийн тайланг хугацаанд нь илгээж, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтөнд хамрагдах 32 иргэний материалыг цахимаар хүлээн авч тайланг илгээсэн ба 520 малчдаас ноолуур зарж борлуулсан орлогын дүнгээс 1% татвар төлүүлж ногдол үүсгэн хувь хүний орлогын албан татварын тайланг гаргаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2 сарын байдлаар нийт 396 тэтгэвэр авагчдад 141023,6 мянган төгрөгийн тэтгэвэр бүрэн олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 303, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 29 иргэн байна.

Сайн дурын даатгалд нийт 67 даатгуулагчийн 3401,7 мянган төгрөг төвлөрүүлж, 1 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулж ажиллав.

Эрүүл мэндийн даатгалд 10 даатгуулагчийн 449,6 мянган төгрөгийн орлого оруулсан ба тэтгэмжийн даатгалын сангаас 1 хүнд оршуулгын тэтгэмжид 1000,0 мянган төгрөг олгосон.

болон гоц халдварт өвчин гараагүй. 2020 оны 02 дугаар сард Алтайн шилмэл сүрэг мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн малын эмч С. Чимэд Аргалант багийн малчин Б. Болдбаатарын 600 толгой бог малыг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан.

Сумын аварга малчдын материалыг хүлээн авч Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Агваш багаас 3, Сээр багаас 5, Аргалант багаас 2 бүгд 10 малчдыг тодруулан, хүнсний нөөцийн болон том зүй бус хорогдлын мэдээний хамт аймгийн ХХАА-н газарт хүргүүллээ.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Амбулатороор 44 иргэн үйлчлүүлж, нийт 10 удаагийн дуудлагад явж, 20 иргэн хэвтэн эмчлүүлсэн төдийгүй гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд 30, сэргээн засах эмчилгээнд 10, оношилгоо шинжилгээнд 34 иргэн хамрагдаж эмчилгээ сувилгааг стандартын дагуу хийж байна

Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж эхийг цаг тухайд нь хяналтанд авч, тайлант 2 дугаар сард БОЭТөвд 4 эх эсэн мэнд амаржиж шинээр 3 эхийг хяналтанд авч ажиллалаа.

Зорилтот бүлгийн 30-60 насны эрт илрүүлэг шинжилгээнд 6, хеликобактерийн шинжилгээнд 12, сахарын шинжилгээнд 7, шээсний ерөнхий шинжилгээнд 11 иргэн тус тус хамрагдаж эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай хүргэж ажиллав.

Цэцэг сум: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал Тэргүүлэгчдийн 2 удаагийн хурал зохион байгуулж, хуралдаанаар Мал эмнэлгийн тасгийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, Шимэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө тухай мөн Мянган Сутайн буян ОНӨААТҮГ-ын тайлан, Түгээмэл тархацтай ашигт малтмалд төлбөр тогтоох тухай, Сонгуулийн хэсгийн хороо байгуулах тухай, Алдарт эхийн одонд тодорхойлох тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Аймгийн ИТХ-ын ажлын албанаас Б.Сандагсүрэн даргаар ахлуулсан ажлын хэсэг хурлын үйл ажиллагаатай танилцан үүрэг чиглэл, зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллав.

Сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах сар шинийн баяр болж байгаатай холбогдуулан 2021 оны 02 дугаар сарын 10 өдрийн сумын Онцгой комиссын 01 дүгээр шийдвэр, сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/17 дугаар захирамжийн дагуу сумын зүүн, баруун талд пост, хяналтын цэгүүд гарган удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллав.

2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн Сургууль, Цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/58 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 22 -ны өдрийн 18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд

Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн хичээлийн бэлтгэл ажлыг хангаж, ариутгал халдваргүйжүүлэлт хийгдэж байна.

Монгол улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газартай хамтран Монгол орны баруун, баруун өмнөд бүсэд 2020 оны 03 сараас эхлэн хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн оролцогч талуудын уулзалтанд хамгаалалтын захиргааны дарга, 3 мэргэжилтэн цахимаар оролцов.

Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид цогцолборт газрын орчны болон хязгаарлалтын бүс Баатархайрхан, Ховол, Дайргат, Нүцгэн, Цахир хамар, Нүцгэний цагаан салаа, Түймэрт, Улаан хүрээ, Шавагт, Зайрангийн ам, Барлаг, Заагийн ам, Хөвч, Тайжийн худаг, замын ам, Халиуны бэлчир, Хужирын тохой, Баянгол зэрэг газруудаар ганцаарчилсан болон хамтарсан 5 удаагийн хяналт шалгалт хийж ажиллав. Цогцолборт газрын орчны болон хязгаарлалтын бүсэд 8 удаагийн ажиглалт судалгаа хийж гүйцэтгэхэд угалз 37, аргаль 87, эмэгж 128, шүдлэн 21, халиун буга 6, чоно 5 тэмдэглэгдэв.

Ажиглалт судалгаагаар цогцолборт газрын бүс нутагт өвс муутай, зарим газраар хүйтний эрч чангарч зэрлэг амьтад идэш тэжээлийн дутагдалд орж болзошгүй тул байршил нутгийн 2 цэгт 50 боодол өвс, 1,5 тонн хужир шүү тавьж, зэрлэг амьтад идэх эсэхийг баталгаажуулах зорилгоор 1 автомат камер байршуулав.

Хамгаалалтын захиргаанаас хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын пэйж хуудсанд 2, орчны бүсийн фэйсбүүк группуудад 6 удаагийн мэдээлэл байршуулж ажиллав.

Мөнххайрхан сум: Сумын Засаг даргын Тамгын газрын хурал 2 удаа, Онцгой комиссын хурал 2 удаа хуралдаж, цаг үеийн ажлын талаар хэлэлцэн, үүрэг чиглэл өгч ажиллав.

Сумын Засаг даргын нийтээр дагаж мөрдөгдөх “Архи согтууруулах ундаа худалдан борлуулах цэгийн цагийн хуваарь тогтоох тухай” 2021 оны А/21 дүгээр захирамжийг тусгай зөвшөөрөлтэй 8 цэг, хэсгийн төлөөлөгч, цагдаа, багуудын Засаг дарга нарт, мөн “Хязгаарлалт тогтоож, гэрийн ажиглалтын хяналтыг чангатгах тухай” А/27, “Хязгаарлалтын хугацаа сунгах тухай” А/31 дүгээр захирамжуудыг Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолын хүрээнд Коронавируст халдвар /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, халдвар тархах эрсдлийг бууруулах зорилгоор 17 дугаар жарны Цагаагчин үхэр жилийн “цагаан сарын баяр”-ыг нийтээр тэмдэглэхгүй байх шийдвэр гарсан тул Мөнххайрхан сумын ард иргэдэдээ хандан уриалга гаргаж, 420 гаруй өрхөд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/62 дугаар захирамж гарсантай холбогдуулан сумын нутаг дэвсгэрээс гарах, орох нийтийн болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 16:00 цагаас 2021 оны 02 дугаар сарын 16-ний өдрийг дуустал түр хугацаагаар хязгаарлаж, сумын төвийн дээд, доод чиглэлд хяналтын пост гаргаж, төрийн 38 албан хаагч, эмч, эмнэлгийн 12 ажилчид, цагдаагийн 3 албан хаагч, 3 жолооч нийт 56 төрийн албан хаагч постонд үүрэг гүйцэтгэв. Сумын ЗДТГ-ын 2 автомашин, эрүүл мэндийн төвийн 1, цагдаагийн 1, нийт 4 автомашин дайчлагдан ажиллаж, 260 литр бензин зарцуулж, Улаанбаатар хот болон бусад голомттой бүсээс ирсэн иргэдийн гэрийн ажиглалтын хяналтыг чангатгаж, эргүүл шалгалт хийх хуваарь гарган, сургууль, цэцэрлэгийн багш ажилчдыг дайчлан ажиллуулав.

Амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай байгаа 8 иргэний асран хамгаалагчийн гэрээг сунгах шийдвэр гаргав. Байнгын асаргаа шаардлагатай 29 ахмад настан, 7 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 1 бүтэн өнчин хүүхдийн судалгааг шинэчлэн гаргалаа.

Хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ авдаг 21 өрхийн 128 иргэнд 1672.000 төгрөгийн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг Их хунт аж ахуй нэгжээр олгож, ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа 5 иргэн, шинээр ажилд орсон 3 иргэний мэдээллийг Lmis.gov.mn програмд шивж ажлын байрны мэдээг холбогдох газарт хүргүүлэв.

Алдарт эхийн 1 дүгээр одонтой 79 иргэнд 15.8 сая төгрөг, Алдарт эхийн 2 дугаар одонтой 136 иргэнд 13.6 сая төгрөг олгож, ахмад насны хишигт 65-69 насны 29 иргэнд 1450.0 төгрөг, 70-79 насны 32 иргэнд 2560.0 төгрөг, 80-89 насны 21 иргэнд 3150.0 төгрөг тус тус олголоо.

Тайлант 2 дугаар сард 2 иргэнд 133.6 мян төгрөгийн ХЧТА-ны тэтгэмж, 1 иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоож 306 иргэнд 114288,0 мянган төгрөгийн тэтгэвэр

олголоо. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 29 иргэн хамрагдаж 1775.9 мян төг, эрүүл мэндийн даатгалд 32 иргэн хамрагдаж 1314.0 мян төгрөгийн орлого тус тус төвлөрүүлээ.

Улсын Онцгой комиссын 2020 оын 12 дугаар сарын 30-ны өдрийн 238 дугаар тогтоол, Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах тусламж дэмжлэг үзүүлэх журмын дагуу Хүнс тэжээл, түлээ нүүрсний хомсдолд орох эрсдэлтэй 40 айл өрхийн судалгааг гарган Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлээ.

Тайлант 2 дугаар сард төрөлт 1, цахим үнэмлэх шинээр захиалсан 1, цахим үнэмлэхний лавлагаа 2, иргэний үнэмлэхний 25, 45 насны сунгалт хийлгэсэн 17, төрсний гэрчилгээний дахин олголтын бүртгэл 6, нас барсны лавлагаа 2, гэрлэлт бүртгэлгүй лавлагаа 1, цахим үнэмлэхний олголт 16, нийт 36 бүртгэл хийж иргэдэд үйлчлэв. Шилжилт хөдөлгөөний 2 төрлийн судалгааг насны бүлгийн ангиллаар нарийвчлан гаргаж, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн насны иргэдийн тоог урьдчилсан байдлаар Алаг баг -351, Борт баг-352, Хаг баг-254, Сэнхэр баг-439 нийт 1396 сонгогчийн тоо гаргаж аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэв.

“Хог хаягдлын тухай хууль, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, сумын төв хөдөөд нохой тэжээхэд тавигдах шаардлага, түүнийг зохицуулах журмын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдөр ЗДТГ-ын эрэгтэй албан хаагчид сумын төвийн эзэнгүй золбин 14 нохойг устгаж, сумын төвд нохойтой байгаа 4 өрхөд шаардлага тавьж, 3 нохойны татвар төлүүлэв.

Янгир ямааны суурьшил бүс нутаг болох Алаг багийн Тасын нуруунд 2021 оны 2 дугаар сарын 9-ны өдөр Мөнххайрханы БЦГ-ын ХЗ-тай хамтран 11 боодол өвс, 300 кг хужир шүү тавьж биотехникийн арга хэмжээ авч уг газартаа 1 автомат камер суурилууллаа.

Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн өмчлөх 1 өргөдөл, газар эзэмших 1 өргөдөл, хэмжээ талбай өөрчлүүлэх 1 өргөдөл хүлээн авч газрын кадастрын системд бүртгэж, өргөдлийг бүрэн шийдвэрлэв. Улсын бүртгэлээс “Э” дугаар авахаар 4 өргөдөл илгээж, 4 өргөдөлд “Э” дугаар олголоо. Газрын нөхөн бүрдүүлэлтийг хийж 141 нэгж талбарын өргөдөл авч кадастр болон захирамжтай холбох бүртгэлийг газрын кадастрын системд оруулж, газар эзэмших эрхийн гэрээ байгуулав. Газрын

хаягийн мэдээллийг засварлах ажлын хүрээнд сумын гудамжны хаягийг замтай холбож, хашаа, байшингийн хаягийг нэг бүрчлэн хаягийн мэдээллийн санд оруулж баталгаажуулав

Санхүүгийн алба нь Шилэн дансны вэйб сайтад төсвийн төвлөрүүлэн захирагчийн сар бүр оруулах 5 мэдээлэл, тухай бүр оруулах 6 мэдээллийг бүрэн шивж хугацаанд нь байршууллаа. Төсөвт байгууллагуудын 2 дугаар сарын санхүүжилтийг ИТХ-д 9622500 төгрөг, ЗДТГ-т 25125400 төгрөг, Соёлын төвд 10439600 төгрөг, ерөнхий боловсролын сургуульд 3031400 төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт 1691700 төгрөг, Эрүүл мэндийн төвд 173000 төгрөг тус тус олголоо.

Төсөвт байгууллагуудын гүйлгээг шивэх, төрийн сангийн бусад үйлчилгээ үзүүлэх, статистик мэдээ гаргаж, 6 төсөвт байгууллагын төрийн сангийн данснаас 56 төлбөрийн хүсэлтээр 137595.4 мянган төгрөгийн гүйлгээ шивж өдөр бүрийн гүйлгээг ня-бо журнал хэвлэн дарааллын дагуу нааж архивын нэгж үүсгэхэд бэлтгэсэн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч 93 иргэнтэй уулзаж зээлийн үлдэгдэл 180371622 төгрөгийн авлагын тооцоонд тооцоо нийлсэн актаар баталгаажууллаа.

Аймгийн санхүүгийн хяналт аудитын албанаас хийсэн хяналт шалгалтаар зээлийн хугацаа хэтэрсэн 7 зээлдэгч иргэнд 1725000 төгрөгийн алдангийн акт тавигдсан 2 иргэнээс 1.0 сая гаруй төгрөгийн акт барагдууллаа.

Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан гаргаж төрийн аудит хийлгэхээр өргөн барьж “Гэрэлт хөхийн тэнцвэр” аудитын байгууллагад хянан шалгуулж “Зөрчилгүй санал дүгнэлт” авлаа.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш нар сургалтын агуулгын таслалтыг судлагдахуун анги бүрээр гаргаж хоцрогдол арилгах төлөвлөгөөг гарган ажиллаж, 435 хүүхдэд теле хичээлтэй уялдуулан даалгавар хүргүүлж ажиллав.

Сумын Эрүүл мэндийн төвд нийт 26 өвчтөн хэвтэн эмчлүүлж, эмийн бус эмчилгээгээр 23 хүнд үйлчилсэн. 0-2 насны 28 хүүхдэд товлолын дагуу дархлаажуулалтанд 100 хувь хамруулж, халдварт саагийн нөхөн дархлаажуулалтанд 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ний хооронд төрсөн нийт 56 хүүхдийг хамруулж дархлаажууллаа.

Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт ирж байгаа иргэд, оюутнуудыг хянах зорилгоор бүртгэл хяналтын хэсэг ажиллуулж, гэрийн ажиглалтын зөвлөмж тарааж, Мөнххайрхан сумын цахим хуудсаар эрүүл мэндийн төвийн хөтөлбөр хариуцагч

мэргэжилтнүүд видео, шторк мэдээллүүдийг тавьж иргэдэд мэдээлэл хүргэж ажиллалаа.

Эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулахад анхаарч 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Ёс зүйн цахим сургалт, аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан КОВИД-19 эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулах цахим сургалтанд вакцинатор, эх баригч, нийгмийн эрүүл мэндийн ажилчдыг хамруулж чадавхжууллаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР